



ОРОС УЛСАД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ СУРАЛЦАХ ГАДААДЫН ИРГЭДИЙН ДУНД ЯВУУЛАХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН НЭГДҮГЭЭР ШАТАНД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Сонгон шалгаруулалт хоёр үе шаттай явагдана. Үүнд:

Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шатыг Гадаад орнуудад ажиллаж байгаа оросын байгууллагууд хэрэгжүүлнэ (Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар /Русский Дом в Улан-Баторе);

Сонгон шалгаруулалтын хоёрдугаар үе шатыг нэгдүгээр үе шатанд шалгарсан гадаадын иргэдийг элсүүлэн суралцуулахыг оросын боловсролын байгууллагууд хэрэгжүүлнэ.

Сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шат нь:

1. Портфолио шалгаруулалт ;
2. Чиглэлийн шалгалт;
3. Баримт бичгийн бүрдүүлэлт зэргээс бүрдэнэ.

Уралдаанд орохын тулд дараах зүйлийг хийх шаардлагатай:

1. Орос Улсад гадаадын иргэдийг элсүүлэн суралцуулах сонгон шалгаруулалтын албан ёсны education-in-russia.com сайт дээр бие даан бүртгүүлэх;

Дараах баримт бичгийг хавсрагах:

1. Цээж зураг
2. Гадаад паспортын скан хуулбар, орчуулга (хүчинтэй байх хугацаа 2024 оны 3-р сарын 1-ээс наашгүй)
3. Боловсролын гэрчилгээний эх хувь, орос орчуулга:
 - сургууль төгсөгчдийн хувьд-**бүрэн дунд боловсролын гэрчилгээ;**



- магистрт суралцах бол **бакалаврын диплом**;
- аспирантурт суралцах бол **магистрын диплом**;
- төгсөх ангийн сурагчдын хувьд: 12 жилийн сургалттай бол 11-р анги, 11 жилийн сургалттай бол 10-р ангийн сүүлчийн аттестатчлалаар гаргасан сурлагын дүн. Баримт бичгүүд сургуулийн захирлын гарын үсгээр баталгаажуулж боловсролын байгууллагын албан ёсны хуудас дээр бичигдсэн байна. Шаардлагатай тохиолдолд бүртгэлийн Комисст сурагчийн хувийн хэргийг гаргаж өгнө;
- бакалаврын сургалтаа дүүргэж магистрт элсэх хүний хувьд **сурлагын ерөнхий дүн** ба их сургуулийн захирлын гарын үсэг бүхий сүүлчийн аттестатчлалаар гаргасан **сурлагын дүн** (дундаж оноо нь монголын боловсролын стандартаар бол 2.8, оросын боловсролын стандартаар бол 4-өөс доошгүй байх);
- 1-2 курсын оюутнуудын хувьд өмнөх боловсролын гэрчилгээ, сургалтын хугацааны сургуулийн тамга бүхий сурлагын тодорхойлолт (дундаж оноо нь 2.8, оросын боловсролын стандартаар бол 4-өөс доошгүй байх), **бүрэн дунд боловсролын** гэрчилгээний хуулбар, орчуулга;
- оросын их дээд сургуулийн бэлтгэл ангид гэрээгээр суралцагсдын хувьд 1-р семестрийн орос хэл, чиглэлийн хичээлийн **сурлагын тодорхойлолт, бүрэн дунд боловсролын** гэрчилгээний хуулбар, орчуулга;
- тусгай дунд мэргэжил эзэмших хүсэлтэй хүний хувьд өмнөх боловсролын сурлагын сайн дүн бүхий тодорхойлолт.

Аспирантурт суралцахын тулд:

- их дээд сургуулиас ирүүлэх зөвшөөрөл бүхий албан тоот (энэхүү зөвшөөрөлтэй горилогчид нэмэлт оноо авах юм);
 - нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсалт;
 - суралцах чиглэлд тохирсон сэдэв бүхий реферат (10-аас доошгүй хуудастай байх).
- 1) Орос хэлний бүсийн олимпиад, 2021 оны хичээлийн жилд явуулсан математик, химийн олимпиадуудад түрүүлсэн бол Гэрчилгээ, бүртгэлийн Комисст эх хувийг гаргаж өгнө.
 - 2) Үндсэн (нэгдүгээр) курст суралцагчдын хувьд “Орос хэлний мэдлэгийг баталгаажуулсан баримт бичгүүд” гэсэн зүйлд орос хэлийг хаана, хэзээ, ямар хугацаатай сурсан тухай мэдээллийг чөлөөтэй маягаар тусгаж



ирүүлэх; хэрэв байгаа бол орос хэлний дамжаанд суралцаж төгссөн **гэрчилгээний** хуулбар, эсвэл одоо суралцаж буй дамжааны тодорхойлолт;

- 3) Орос хэлний Зуны сургалтанд суралцах горилогч (орос хэлний багш, монголын их дээд сургуулиудын орос хэлний ахлах курсын оюутан)-ийн хувьд дээд сургуулийн дипломын хуулбар, орчуулга, сургууль, ажлын газрын тодорхойлолт;
- 4) Өөрийн хувийн амжилтын скан-хуулбар орчуулгын хамт, гэхдээ 2019 оноос өмнө гаргасан амжилт орохгүй (Диплом, хүндэт бичиг гэх мэт).

Чухал: сонгон шалгаруулалтанд сурлагын сайн дүнтэй боловсролын гэрчилгээтэй горилогчдыг оруулна. Гол бус 1-2 хичээлд «С» буюу «дунд» үнэлгээтэй байж болно. (Хавсралт 1.2)

“Ноорог” байдлаар бичигдсэн мэдүүлгийг хүлээн авахгүй !!!

Мэдүүлэгдээ хуурамч эсвэл бүрэн бус мэдээлэл тусгасан горилогчдын нэгдүгээр шатны дүнг хүчингүйд тооцож, баримт бичгийг шалгаруулалтын хоёрдугаар шатанд оруулахгүй татаж авна.

Оруулж буй бүх баримт бичиг чанартай тод сканердаж уншихад төвөггүй байвал зохино . Боловсролын баримт бичиг, эмнэлгийн магадлалын орчуулгыг заавал хавсрагна.

Горилогчид нэг чиглэл/мэргэжилээр боловсролын нэг түвшний хүрээнд шалгаруулалтанд орж болно.